



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 13/44

Улаан-Уул

Гамтарсан багийн 2023 оны
ажлын төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1 дэх, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 13 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь;

1. Гамтарсан багийн 2023 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.


2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулж буй үйл ажиллагааг улам идэвхжүүлэх, хүчирхийлэл гарахад нөлөөлж буй хүчин зүйлийг арилгах, хүн амыг соён гэгээрүүлэх арга хэмжээг тасралтгүй зохион байгуулахыг гамтарсан багийн ахлагч Засаг дарга (Т.Эрдэнэбат)-д даалгасугай.

ДАРГА  С.ГОНГОР



Ёсчилсон 2022 оны 12 сарын 19 ны өдөр

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
13 дугаар хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний
өдрийн 13/44 дүгээр тогтоолын хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ХАМТАРСАН
БАГИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Зорилтууд	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт	Хугацаа	Шаардагдах зардал	Хариуцах хүн
1	2	3	4	5	6	7
Хүчирхийллийг эрт шатанд илрүүлэх арга хэмжээний хүрээнд:						
1	Хамтарсан багийн гишүүдийн болон, төрийн албан хаагчдын хамтын оролцоог жигд ханган ажиллах	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	-Эрсдэлийг тооцох нэгдсэн үзүүлэлтийг гаргаж улмаар эрсдэлийг бууруулах арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлнэ. /тээврийн хэрэгсэл жолооддоггүй, тамхи татдаггүй, үе тэнгийн дарамт хүчирхийлэлгүй сургууль болох/ -Илэрсэн эрсдэл бүрт холбогдох кейс нээж шийдвэрлэнэ. -Гэрээр айлчилж эрсдэлийг илрүүлнэ	1-р улиралд	500.0	ХБ-ийн бүх гишүүд, Сургууль, Цэцэрлэгийн Хүүхэд хамгааллын багийн гишүүд, Эрүүл мэндийн эмч, ажиллагсад
2		Хүн ам, өрхийн нарийвчилсан судалгааг гаргах	-Байгууллага, холбогдох албан тушаалтан	1-р улиралд		ХБ-ийн болон Хүүхэд хамгааллын багийн гишүүд
3		Байгууллагын удирдлагууд албан хаагчдын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын талаар зээлт тусгах	-Төлөвлөгөөнд оруулах заалтыг нэг бүрчлэн гаргаж өгөх -Гэрээ, төлөвлөгөөнд тусгасан байна.	1-р сард		Байгууллагын дарга нар, ХБ-ийн нарийн бичгийн дарга
4		Эргүүл жижүүрийг тогмолжуулж хүчирхийлэл үйлдэж болзошгүй бүртгэлд байгаа иргэний хөдөлгөөн, тавиул хүүхдүүдийг хянах	-Хамтарсан багийн хурлаар нэрсийг гаргаж хянах - Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн болон шүүхээр хариуцлага хүлээсэн гэр бүлтэй эргэн дүгнэх уулзалт хийж хэвших -Архинаас татгалзсан иргэнээр нөлөөллийн арга хэмжээг явуулах, урамшуулах /Цэрэнтогтох/	Жилийн турш	500.0	БЗД нар, НБ-ын мэргэжилтэн, цагдаагийн ажилтнууд

2.

1	2	3	4	5	6	7
5		Байгууллагын Хүүхэд хамгааллын журмыг ажлын хэсэг гарган шинэчлэн боловсруулах, эцэг эхийн зөвлөлийн байгуулах үндэслэлийг тогтоох	-Засаг даргын захирамжаар ажлын хэсэг гарган шийдвэрлэх	1-р улиралд		НБМ
6		Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх сургалт зохион байгуулж уралдаан зарлах	-Сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулах. -Болзолт уралдааны удирдамж батлах	1-р улиралд	500.0	НБМ
7		Сургууль, Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх	-Аймгийн ГБХЗХГ-тай хамтран сургалтанд хамруулах -Хамтарсан багийн хурлаар хэлэлцдэг болох -Кейс шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	Эхний хагас жилд		Байгууллагын дарга нар НБМ
8		Хамтарсан багийн хурлыг сар бүр хуралдуулах	-Кейс хурлыг тухай бүр хуралдуулаж шийдвэрлэж байх	Тухай бүр		НБМ
9	Эцэг эхчүүдийг чадавхжуулах	Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга сургалтыг эцэг эхчүүдийг хамруулан зохион байгуулах	-Эцэг эхчүүдийн оролцоог бүхий л түвшинд хангах -Сургалтын багийг байгуулах	Жилдээ	1000.0	Сургалтын баг
10		Эцэг эхчүүдээ сонсьё арга хэмжээг зохион байгуулах	-Тулгарч буй асуудлыг илрүүлж, шийдвэрлэх	Жилдээ	1500.0	Хамтарсан баг
11		Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх самбарыг нийтийн эзэмшлийн газарт байршуулах	-Архидан согтуурах тухай, -Зөрчлийн тухай хуулиар	2 дугаар улиралд	500.0	Цагдаагийн ажилтнууд, НБМ
12	Хүүхдийн оролцоог дэмжин хөгжүүлэх	Хүүхдийг чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулах	-Багийн ажил гэж юу болох -Үе тэнгийн дарамт хүчирхийлэл	Улирал бүр	500.0	Хамтарсан баг, Хүүхэд хамгааллын багууд
13		ХӨУБ-ын үйл ажиллагааг дэмжин төсөлт арга хэмжээг зохион байгуулах	-Санхүүгийн дэмжлэг үзүүлэх -5-с доошгүй төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх	Тухай бэр	1000.0	Хамтарсан баг, Хүүхэд хамгааллын багууд
14		"Хүүхдээ сонсьё" арга хэмжээг зохион байгуулах	-Хүүхдийн чуулганаас гарсан саналыг байгууллагын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх -Хүүхдийг хүүхдээр нь алдаршуулах арга хэмжээг зохион байгуулах	2,4 дүгээр улиралд	500.0	Хамтарсан баг, Хүүхэд хамгааллын багууд

1	2	3	4	5	6	7
15	Нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлэх	Тэмдэглэлт өдрүүдийг Тэмдэглэлт өдрүүдээр ахмад, эмэгтэйчүүд, хүүхэд, залуучуудын байгууллагын оролцоог хангаж гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх /сургалт, уулзалт, уралдаан тэмцээн, хэлэлцүүлэг.../	-ТББ бүртэй хамтран нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Тухай бүр	1500.0	Хамтарсан баг
16		Соён гэгээрүүлэх лекцийг иргэд олон нийтийг хамруулан зохион байгуулах	-Ард иргэдийг хамруулан 5-с доошгүй арга хэмжээг явуулах	Жилийн турш	5500.0	Хамтарсан баг, Хүүхэд хамгааллын багууд
17		Сумын харьяат нийгмийн ажилтанаар ажиллаж байгаа иргэдтэй уулзалт зохион байгуулж арга туршлага солилцох, төсөлт арга хэмжээг хамтран зохион байгуулах, үйл ажиллагаа нь тогтмолжсон хамтарсан баг, эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаатай танилцах ажлыг зохион байгуулж чадавхжуулах	-Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах -Жинст сумын ажилтай танилцах	3 дугаар улиралд	1000.0	Хамтарсан баг
18		Гэмт хэрэг, зөрчлийн дуудлагад багийн Засаг дарга, цагдаагийн ажилтнууд хамтдаа явж нөхцөл байдлыг шуурхай хянан шийдвэрлэж хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчийг тусгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх	-Гишүүдийн хамтын үйл ажиллагаа сайжирна. -Кейсийг шуурхай бүртгэн хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ	Тухай бүр		Цагдаагийн ажилтнууд, Багийн Засаг дарга нар
19		Хөрш-Айлын ахлагч нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулах	-Гэмт хэрэг зөрчлийн илрүүлэлт нэмэгдэнэ. -Айл өрхийн хамтач байдал сайжирна. -Хөрш айл дээр сургалт зохион байгуулах	2 дугаар улирал	1000.0	Хамтарсан баг
20		Гэр бүлийн хүчирхийллийн талаар зохион байгуулж буй ажлын талаар сумын ГХУСАЗСЗ болон ИТХ-д мэдээлэх	-Улирал бүр мэдээллийг хийж хамтын ажиллагаа сайжирна.	Улирал бүр		НБМ

4.

1	2	3	4	5	6	7
21		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах.	-Зорилтод сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.	8, 12-р сард	1000.0	Хамтарсан баг
22		"Миний хүүхэд-Монголын ирээдүй" аян зохион байгуулах	-Удирдамж гарган хэрэгжүүлэх -Үгээрээ биш үйлдлээрээ үлгэрлэгч – Өлзийтчүүд аян - Архигүй гэр бүл аян зохион байгуулах -Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдрийг тэмдэглэх - Осол гэмтлээс сэргийлэх 10 хоногийн аян -Хүний эрх, Хүүхдийн эрхийн талаарх ОУ-ын өдрийг угтан сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах	01-06.01 сар хүртэл	1500.0	Хамтарсан баг
23	Хохирогчийг хамгаалах	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр байршуулах хамгаалах байрыг бий болгон тохижуулах	-Хамгаалах байртай болсоноор	2 дугаар улирал		Хамтарсан баг
24		Хамтарсан багийн үйл ажиллагааны бичиг хэрэг, шатахууны зардлаар хангах	Үйл ажиллагааны зардалд дэмжлэг үзүүлсэн байна.	Жилдээ	2000.0	Хамтарсан баг
ДҮН					20,000.0	

-----oOo-----